

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЧАГТАЛТУЛГЫН МӨНХХИШИГИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт, хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах								
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнана.	ЗУГ-аас 2024 оны 05 дугаар сарын 30-нд ирүүлсэн дотоод зурвасын дагуу дараах эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны өөрийн нэгжид хамаарах хэрэгжилтийн тайлан, мэдээг гаргаж заасан хугацаанд нь хүргүүлсэн болно. Үүнд: 1. Сургалтын төвийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2. Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 3. Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 4. Гаалийн байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн биелэлт 5. Гаалийн байгууллагын 2024 оны "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлт Мөн ГЕГ-ын нэгжүүдээс ирүүлсэн дараахь эрх зүйн актын төсөлд саналаа цаг хугацаанд нь дотоод зурвасаар хүргүүлж байсан болно. Үүнд: 6. "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөл 7. "ГУБ-ийн үйлчилгээний стандартын журам"-ын төсөл 8. "ГУБ-ийн сахилгын дүрэм"-ийн төсөл 9. "ГУБ-ийн ёс зүйн дүрэм"-ийн төсөл	01.01-11.30		

				<p>чиглэлээр номын сан байгуулах 3.Заах арга зүйг боловсронгуй болгох хүрээнд жишиг сургалтын хөтөлбөр боловсруулах</p>	<p>-2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр "Мөнх Хан Хархилуун" ХХК-тай хийгдсэн 19,990,000 төгрөгийн өртөгтэй гэрээний дагуу номын сангийн 78.3 мк тавиур хийх, суурилуулах ажил 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс гэрээнд заагдсан хугацаанд буюу 7 хоногт багтаан, 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр бүрэн дуусгаж, ажил дүгнэсэн болон гэрээ дүгнэсэн акт үйлдэгдэн, хүлээлгэн өгснөөр дуусгавар болсон. ГЕГ-ын Үйлчилгээ, аж ахуйн албанаас 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нийт 818 төрлийн 48.521.978.71 төгрөгийн үнэ бүхий номыг хүлээж авч, номын санд байршуулан тавьсан.. /Номын сангийн зургийг тайлангийн дагалдах файлд хавсаргасан болно./</p> <p>- Мөн VR сургалтын танхим 2024 оны 2 дугаар сарын 1-нээс нээсэнтэй холбоотойгоор ГУБ нарт зориулсан VR технологид суурилсан "L-THURSDAY 1.0" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ГЕГ-ын дарга Р.Отгонжаргалаар батлуулсан.</p> <p>-Сургалтын орчин нөхцөлийг дэвшилтэт технологи ашиглан сайжруулах ажлын хүрээнд компьютерийн лабораторид 15ш шинэ Dell иж бүрдэл компьютераар сэлбэн шинэчилсэн ба мөн 206 тоот сургалтын танхимд шинээр 85inch ухаалаг дэлгэц ашиглан, сургалтаа явуулж байна.</p> <p>-“Зайн сургалтын төв байгуулах төсөл боловсруулах” ажлын хэсгийн тушаалыг төлөвлөж, ГЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>		
					-Цахим сургалтын платформтой болох хэрэгцээ, шаардлагыг ГЕГ-ын даргад танилцуулан улмаар Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.		
2	Албан хаагчдыг чадавхжуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	92%	<p>1.Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт 2 удаа /80 суралцагч/, 2. ГУБ нарын мэргэшүүлэх сургалт 6 удаа /150 ГУБ/,</p>	<p>Сургалтын төвөөс 2024 онд ГЕГ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөө болон удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт – 4 удаа, ГУБ нарын мэргэшүүлэх сургалт – 3 удаа, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт – 3 удаа, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалт – 1, VR мэргэшүүлэх сургалт -1, цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалт, нийт 13 сургалтыг тус тус</p>	01.01-11.30	

				<p>судлал-2” эмхэтгэлийн ажил бүрэн дуусч, дарга нарт танилцуулагдсан бөгөөд 30 ширхгийг хэвлүүлэн, ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар, хороодод тараасан.</p> <p>- “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдэх эрдэм шинжилгээний ажил, ном, бүтээлийн бүртгэлжүүлэх, нэгдсэн сан үүсгэх ажлыг дөрвөн чиглэлээр материал цуглуулж, CERP програмд “Гааль судлал” дэд цэс үүсгэн байршуулах ажлыг багш нарын хамт зохион байгуулсан.</p> <p>- Сургалтын төв нь Монгол Улсад худалдааны салбарын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жил, Гаалийн байгууллага үүсэж, хөгжсөний 112 жил, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тохиолдуулан “ГЛОБАЛ БИЗНЕС ДЭХ ШИНЭ ХАНДЛАГА” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-тай хамтран 2024 оны 10 дугаар сарын 25-нд зохион байгуулсан. Тус хуралд худалдаа, гааль, глобал бизнесийн шинэ хандлагын талаар нийт 100 гаруй олон улсын болон дотоодын эрдэмтэн, судлаач, экспертүүд болон гаалийн байгууллагын албан хаагч, бусад байгууллагын төлөөлөл илтгэлүүдээ хэлэлцүүлэн оролцлоо. Уг хуралд Сургалтын төвөөс ГУАБ Л.Олонбаяр “Цаасгүй худалдааг хэрэгжүүлж буй зарим орны туршлага, Монгол Улсын авах сургамж” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.</p> <p>Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024” хөтөлбөр”-ийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.</p>		
4	Бусад байгуулагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	50%	<p>- 2024 оны эхний хагас жилд ГЕГ-аас МУИС болон ХААИС-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгууллаа. Энэ хүрээнд гаалийн хүний нөөцийг бэлтгэх, тус сургуулийн тусгай зөвшөөрлийг харгалзан элсэгчдийн хяналтын тоог тогтоох, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гаалийн албан хаагчийн ажлын байрны сургалт дээр дэмжлэг үзүүлэх зэрэг энэ чиглэлээр олон талт ажлуудыг хамтран хэрэгжүүлэх юм.</p> <p>ГЕГ, МУИС-ийн хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд:</p> <p>- Сургалтын төв нь Монгол Улсад худалдааны салбарын мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жил, Гаалийн байгууллага үүсэж, хөгжсөний 112 жил, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг</p>	01.01-11.30	

					<p>гишүүн орны гаалийн байгууллагуудын "Сургалтын менежмент" уулзалт, сургалтад оролцсон.</p> <p>-- ГУАБ Л.Олонбаяр УА-ийн төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх болон давтан багц сургалтад тус тус хамрагдаж, амжилттай төгссөн.</p> <p>- Багш ГУБ Н.Анужин Үндэсний тагнуулын академийн эрх зүйн бакалаврын эчнээ хөтөлбөрт хамрагдан суралцаж, эхний улирал амжилттай төгссөн. Мөн Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Монгол бичгийн анхан, дунд, ахисан түвшний цахим сургалт, Ёс зүйн анхан, дунд, ахисан түвшний цахим сургалтуудад тус тус хамрагдаж, үнэмлэх авсан.</p> <p>- Бусад багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах талаар хийсэн тайланг файлаар харуулж байна.</p> <p>-Залуу багш нарыг чадавхжуулах зорилгоор менторшип хөтөлбөр хэрэгжүүлж ахмад багш нар болох Ж.Булган "Гаалийн удирдлага", "Гаалийн бүрдүүлэлтийн горим" С.Норжинсүрэн "Олон улсын худалдаа, гаалийн үнэ, үнэлгээ", С.Энхтуяа "Барааны ангилал" хичээлээр хэрхэн заах арга барилаа сайжруулах, сургалтын агуулгыг хэрхэн чанартай хүргэх, харилцан туршлага солилцох ажлыг 2024 оны 03 дугаар эхлэн хэрэгжүүлж эхлээд байна.</p>		
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	<p>- Сургалтын төвөөс "Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратегийн төлөвлөгөө" бодлогын баримт бичигт өөрийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулахад саналаа өгч, ЗУГ-т хүргүүлсэн.</p> <p>- Сургалтын төвийн багш нарын хамтаар 2024 онд ГЕГ-аас МУИС болон ХААИС-тай хамтран ажиллах "Санамж бичиг" боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан.</p>		
					<p>- Багш ГУБ О.Отгонгэрэлийн гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд найрамдах Узбекистан Улсын Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийн зүйл III хамтран ажиллах, харилцан туслах арга хэмжээний 2f, g, h хэсгийн хамрах хүрээнд санал боловсруулах, мөн багш ГУБ Г.Баярмаа, Н.Нямгэрэл нарын ДГБ-ын болон Швейцарийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан 2024-2027 оны хооронд хэрэгжих "Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр"-ийн 2 дугаар шатанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд</p>		

					<p>эрсдэлээс сэргийлж, төвөөс дараахь 2 арга хэмжээг авч ажилласан. Үүнд:</p> <p>1. ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодыг багш нарт хуваарилж өгсөн</p> <p>CERP програмаар ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодод тайлан ирүүлэх талаар хугацаатай үүрэг, даалгавар өгсөн</p>		
8	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	<p>1. Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.</p> <p>2. Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.</p>	<p>2024 оны тайлант хугацаанд удирдлагаас Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /ГЗДАС/ програмаар дамжуулан нийт 9 үүрэг даалгавар өгөгдсөн. Энэхүү үүрэг даалгаврыг төрлөөр нь ангилбал:</p> <p>- Үүрэг даалгавар – 5:</p> <ul style="list-style-type: none"> - Зөвлөмж - 1 - Онлайн хурлын даалгавар – 2 - Ёс зүйн дэд хорооны хуралдаан – 1 <p>Төлвөөр нь задалбал:</p> <ul style="list-style-type: none"> - "Илгээсэн "төлөвтэй - 1, - "ХШУДАГ дүгнэсэн" төлөвтэй – 8 <p>ГЕГ-ын удирдлага -1, ХШУДАХ-ээс – 1, ЗУГ-аас – 4, ЭУХ-ээс 3 удаа тус тус үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг цаг хугацаанд нь програмд оруулж, дунджаар 98,6 хувьтай дүгнэгдсэн байна.</p> <p>Мөн Сургалтын төвөөс 2024 онд ГЕГ-ын ЗББНДБ болон харъяа гаалийн газар, хороодод сургалт, гааль судлал, ГЕГ, МУИС-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлэх талаар нийт 7 үүрэг даалгавар хүргүүлсэн. Эхний хагас жилийн үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэхдээ 21 хоногоор хоцроон үнэлсэн тул ХШУДАГ-аас А/190 дүгээр тушаалын дагуу 00 оноогоор үнэлэгдсэн алдаандаа дүгнэлт хийж ажиллан, сүүлийн хагас жилийн үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь дүгнэж, програмд оруулсан.</p> <p>Тайлант хугацаанд ГЕГ-ын дарга, дэд дарга, ГЕГ-ын ЗББНДБ-аас дотоод зурвасаар 156 албан бичиг ирсэн бөгөөд үүнээс 71 албан бичиг хариутай байсан ба хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Тайлант хугацаанд EDос програмаар нийт төрийн болон төрийн бус 20 байгууллагаас давхардсан тоогоор 59 албан бичиг ирснээс 58 албан бичгийн хариуг шийдвэрлэж, цаг хугацаанд нь хүргүүлсэн ба 1 албан бичгийн хариуг өгөх</p>	01.01-11.30	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5		6	7	
1	ЖАЙКА олон улсын байгууллагын "Гаалийн удирдлага" сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Япон улсын Токио хотноо хамрагдаж, гэрчилгээ авсан байна.	2024 оны 10 сарын 7-ноос 11 сарын 1-ний хооронд Япон улсын гаалийн байгууллагын үйл ажиллагаатай танилцан, туршлага судлан, улмаар сургалтын цахим платформтой болох хэрэгцээ шаардлагын талаар танилцуулга бэлтгэн хэлэлцүүлж, сургалтаа амжилттай дүүргэж, гэрчилгээ авсан.		01.01-11.30	
2	ОХУ-ын Санкт-Петербург хотноо гаалийн академигаар танилцах, туршлага судлах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.	2024 оны 9 сарын 27-ноос 10 дугаар 05-ны хооронд ОХУ-ын Санкт-Петербург хотноо гаалийн академи, ИСБА компани, ЛЕТИ их сургуулийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлан, гаалийн албан хаагчдын рентген тоног төхөөрөмж дээр ажиллах чадварыг дээшлүүлэх богино хугацааны сургалтын талаар хамтран ажиллах санал хүсэлтийг тавин, шийдүүлэхээр ажиллаж байна.		01.01-11.30	
3	Мэргэжлийн орчуулга хийж, англи хэлний чадвараа ахиулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Ёс зүйн дэд хороотой хамтран ДГБ-ын "Ёс зүйн загвар дүрэм" 15 хуудас материалыг орчуулсан байна.	ДГБ-ын "Ёс зүйн загвар дүрэм"-ийг орчуулан Ёс зүйн дэд хорооны дарга Д.Цэндсүрэнд хүргүүлсэн.		01.01-11.30	

					сагсан бөмбөгийн төрөл алт, гар бөмбөгийн төрөлд мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлсэн.		
11	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-		- 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд АТГ-т мэдүүлэн, ГЕГ-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. - 2024 онд АТГ-аас "Авлигын гэмт хэрэг, шалтгаан, хор хөнөөл" сэдвээр нийт 4 удаагийн 8 цаг, багш-ГУБ О.Отгонгэрэл, Ж.Жаргал-Эрдэнэ нар "ГУБ-ийн ёс зүй ба авлигаас урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалтын хөтөлбөрийн дагуу 28 цаг, нийт 36 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 903 суралцагч /АТГ -н сургалтад -207/ хамрагдсан байна. Эдгээр сургалтыг зохиолн байгуулах, хяналт тавих, тайлан хүргүүлэх ажлыг гүйцэтгсэн.	01.01-11.30	

ТАЙЛАН ГАРГАСАН:

СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Ч.МӨНХХИШИГ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР